## ГАРЧИГ

**БҮЛЭГ 1. ОРШИЛ** ..... 4
**БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ..... 5
2.1. Төслийн нэр ..... 5
2.2. Төсөл хэрэгжүүлэгч ..... 5
2.3. Төслийн байршил ..... 5
2.4. Ордын нөөц ..... 7
2.5.Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим ..... 7
2.6.Ажиллах хүч ..... 8
2.7.Ашиглалтын системийн сонголт, тоног төхөөрөмж ..... 8
2.8.Уурхайн цахилгаан болон усан хангамж, дэд бүтцийн бэлтгэл ..... 8
2.10.Уурхайн дэд бүтэц ..... 9
2.11.Усан хангамж ..... 9
2.12.Цахилгаан хангамж ..... 9
2.13.Хөдөлмөр аюулгүй ажиллагаа ..... 9
**БҮЛЭГ 3. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ..... 10
**БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ** ..... 11
**БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ** ..... 16
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 16
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ..... 22
2025 онд нөхөн сэргээлт хийгдэхгүй болно. ..... 22
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 22
5.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 26
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 26
5.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 27
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 31
5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... 34
5.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт ..... 35
5.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ..... 36
**2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ** ..... 39
**ДҮГНЭЛТ** ..... 40
**АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ** ..... 41

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ....5
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол ....5
Хүснэгт 3. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт ....7
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим ....7
Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл ....11
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....16
Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....22
Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ....27
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ....31
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ....34
Хүснэгт 11. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт ....35
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт ....36
Хүснэгт 13. 2025 оны БОМТ-нд зарцуулсан нийт зардал ....39

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Баян ам” нэртэй  дайрганы ордын байршлын зураг ....6
Зураг 2. “Баян ам” нэртэй  дайрганы ордын байршлын зураг ....6
Зураг 3. 2025 оныгГазар ашиглах гэрээ ....18
Зураг 4. Уурхайн дотоод тээврийн зам ....19
Зураг 5. Уурхайн дотоод тээврийн зам ....19
Зураг 6. Уурхайд таних тэмдэг байршуулсан байдал ....20
Зураг 7. Уурхайд таних тэмдэг байршуулсан байдал ....20
Зураг 8. Ус ашиглуулах дүгнэлт ....21
Зураг 9. Уурхайн талбайд мод бут тарьсан байдал ....23
Зураг 10. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил ....23
Зураг 11. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил ....24
Зураг 12. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил ....24
Зураг 13. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил ....25
Зураг 14. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил ....25
Зураг 15. Галаас сэргийлэх багаж хэрэгсэл байршуулсан байдал ....28
Зураг 17. Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан байдал ....29
Зураг 18.Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авах эмийн сан ....29
Зураг 19.Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар 30
Зураг 20. 2025 оны хог хаягдлын гэрээ ....32
Зураг 21. Хог хаягдлын цэгийг хашаажуулсан байдал ....33
Зураг 22. Нийгмийн хариуцлагын хүрээнд үерийн усанд автсан гудамжны замыг шороогоор булж тэгшилсэн байдал ....35
Зураг 23. Хөрсний зүсэлт, Хөрсний агрохимийн, хөрсний хүнд металлын шинжилгээний дүн ....37

Зураг 24. Гүний худаг, усны шинжилгээний дээж авч буй байдал ....................................................37
Зураг 25. Усны шинжилгээний дүн ........................................................................................38

# БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Баян ам” нэртэй дайрганы ордын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

**БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах аргачлал:**

Тус төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежменгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Баян ам” дайрганы ордын БОМТ-ний биелэлтийн тайланд 2025 онд нийт **28,562,540** төгрөг зарцууллаа.

# БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

***Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл***

| № | Үзүүлэлтүүд | | |
|---|---|---|---|
| 1 | Аж ахуйн нэгжийн нэр | | “Амьдралын илч” ХХК |
| 2 | Улсын бүртгэлийн дугаар | | 2911003058 |
| 3 | Уурхайн нэр | | “Баян ам” нэртэй дайрганы орд ашиглах төсөл |
| 4 | Ордын байршил | Нийслэл/Хот/ Аймаг | Улаанбаатар хот |
| 5 | | Сум/Дүүрэг | Налайх дүүрэг |
| 6 | Ашигт малтмалын төрөл | | Дайрга |
| 7 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | | 18/M011 |
| 8 | Аж ахуйн нэгжийн хаяг | Аймаг/Хот | Улаанбаатар хот |
| 9 | | Сум/Дүүрэг | Налайх дүүрэг |
| 10 | | Баг/Хороо | 1-р хороо, Өвөршандын 2-4 тоот. |
| 11 | Захирлын хаяг | Нэр | Захирал Ж.Амьдралхүү |
| 12 | | Гар утас | 976-96006580 |

## 2.1. Төслийн нэр

“Баян ам” нэртэй дайрганы орд ашиглах төсөл

## 2.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Амьдралын илч” ХХК

## 2.3. Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 36 км, Налайх дүүргээс зүүн хойш 4 км зайд байрладаг. Засаг захиргааны хувьд Налайх дүүргийн 1-р хорооны нутагт харьяалагдана.

Нийт 27.3 га талбайтай.

***Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол***

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 107 | 18 | 41.7 | 47 | 47 | 45.76 |
| 2 | 107 | 19 | 5.9 | 47 | 47 | 45.76 |
| 3 | 107 | 19 | 9 | 47 | 47 | 38 |
| 4 | 107 | 19 | 9 | 47 | 47 | 29.44 |




*Зураг 1. “Баян ам” нэртэй  дайрганы ордын байршлын зураг*




*Зураг 2. “Баян ам” нэртэй  дайрганы ордын байршлын зураг*

## 2.4. Ордын нөөц

“Баян ам” нэртэй дайрганы ордод явуулсан хайгуулын дүнгээр батлагдсан нөөцийг дараах хүснэгтэд харуулав. Түгээмэл тархацтай ашигт малтмал дайрганы олборлолтыг ил уурхайн хэлбэрээр 10 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон байна.

***Хүснэгт 3. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт***

| № | Нөөцийн блокийн дугаар | Дайрганы огтлолын дундаж талбай мян.м$^2$ | Зүсэлт хоорондын джндаж зай, м | Дайрганы нөөц, мян.м$^3$ | Дайрганы нөөц, мян.тн | Блокийн талбай мян.м$^2$ | Хөрсний зузаан, м | Хөрсний эзлэхүүн, мян.м$^3$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | B-I | 6.32 | 223.5 | 1413.38 | 3816.14 | 43.94 | 2.28 | 100.2 |
| 2 | B-II | 7.5 | 195.93 | 1469.7 | 3968.2 | 39.29 | 2.45 | 96.27 |
| **Нийт B** | | | | 2883.09 | 7784.34 | 83.24 | 2.36 | 196.46 |
| 3 | C-1 | 2.73 | 212.22 | 578.41 | 1561.7 | 20.49 | 2.2 | 45.09 |
| 4 | C-2 | 3.14 | 194.15 | 609.25 | 1644.99 | 19.07 | 2.5 | 47.67 |
| **Нийт C** | | | | 1187.7 | 3206.69 | 39.56 | 2.35 | 92.76 |
| **Бүгд B+C** | | | | 4070.75 | 10991.02 | 122.8 | 2.35 | 289.2 |

## 2.5.Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим

Уурхайг нийт 10 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан ба 4 сарын 01-нээс 11 сарын 01 хүртэл 8 сарын хугацаанд үйл ажиллагаа явагдана. Олборлолт болон бутлалт, шигшилт тасралтгүй 6 сар үргэлжилнэ.

Ил уурхайн жилийн хүчин чадлыг, уул техникийн нөхцөл, захиалагч байгууллагаас уг төслийг боловсруулах техникийн даалгавар зэргийг харгалзан жил тус бүр 150.0 мян.м$^3$ дайрга олборлохоор тооцлоо.

***Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим***

| № | Нэрс | Хэмжих нэгж | Жилд |
|---|---|---|---|
| 1 | Жилийн хуанлийн өдөр | хоног | 214 |
| 2 | Амралт, баяр ёслол | хоног | 4 |
| 3 | Цаг агаарын хүндрэл | хоног | 16 |
| 4 | Урсгал засвар хийгдэх | хоног | 14 |
| 5 | Уурхайн ажиллах ажлын өдөр | хоног | 180 |
| 6 | Уурхайн бэлтгэл ажил | хоног | 10 |
| 7 | Хөрс хуулах хоног | хоног | 170 |
| 8 | Олборлолт явуулах хоног | хоног | 165 |
| 9 | Хоногийн ээлжийн тоо | ээлж | 2 |
| 10 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 8 |

**2.6.Ажиллах хүч**

Захиргаа, ил уурхай, бутлан ангилах боловсруулах хэсэгт нийтдээ 44 хүн ажиллана.

**2.7.Ашиглалтын системийн сонголт, тоног төхөөрөмж**

“Баян ам” дайрганы ордын ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл энгийн тул авто тээвэртэй ашиглалтын системээр, ил аргаар ашиглах юм.

Олборлолтын ажлыг “Экскаватор-автосамосвал”-ын хослолоор явуулна. Эхэлж дунджаар 2.65 м зузаантай шимт хөрс болон хөрсийг хуулж овоолго үүсгэсний дараа 5 мн доголоор дайргыг экскаватор CAT-320C, HOWO автосамосвалын хослолоор тээвэрлэн буталж, шигшиж барилгын материалын үйлдвэрлэлд нийлүүлэх стандартын шаардлагад нийцүүлэн хэрэглэгчдэд нийлүүлнэ.

“Баян ам” дайрганы ордын ашиглалтын үндсэн үйл ажиллагаа нь:

- Үржил шимт өнгөн хөрс хуулах
- Өрөмдлөг тэсэлгээний ажил хийх
- Хөрс хуулах
- Дайрга олборлох
- Олборлосон дайргыг бутлах төхөөрөмжийн ойролцоо тээвэрлэн буулгах
- Бутлагдсан дайргыг шигших
- Боловсруулагдсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх
- Хөрсний овоолго, тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил
- Уурхайн бэлтгэл ажлаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- Ажилчдын орон сууц барих, суурин байгуулах
- Тээврийн хэрэгсэл зорчих зам бэлтгэх
- Сэлбэг хэрэгсэл, шатахуун тос агуулах сав бэлтгэх, байрлуулах
- Уурхайн талбайг үерээс хамгаалах далан, шуудуу байгуулах
- Бутлах, шигших тоног төхөөрөмжийг угсрах, байрлуулах.

**2.8.Уурхайн цахилгаан болон усан хангамж, дэд бүтцийн бэлтгэл**

Төслийн үйл ажиллагаанд доорх машин техник, тоног төхөөрөмжийг хэрэглэхээр ТЭЗҮ-д тусгасан байна.

**2.9.Өрөмдлөг тэсэлгээний ажил**

Уурхайд хөрс хуулах болон дайрга олборлох ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн JK358H маркийн цахилгаан өрмийн машин 1ш ашиглахаар сонгосон байна.

Уурхайн доголын өндөр 5м, налуугийн өнцөг 60-900 байхаар тооцсон бөгөөд 1м цооног тэслэхэд 18.1-22.2 $м^3$ уулын цул тэсэлнэ. Жилд тэслэх уулын цулын нийт хэмжээ нь 150-260.4 мян.$м^3$ ба 12 удаагийн тэсэлгээ хийгдэхээр тооцоолсон ба АНФО төрлийн тэсрэх бодис (Аммонийн нитрат ба дизель түлшний хольц), тэсрэх хэрэглээнд Нонель системийг хэрэглэнэ.

## 2.10.Уурхайн дэд бүтэц

***Авто зам*****:** Уурхайн дотоод зам нь шилжилт хөдөлгөөн их хийгддэг тул шилжилттэй түр замаар хөрс болон дайрга тээвэрлэхээр тооцсон байна. Уурхайгаас дайрганы овоолго болон засвар механикийн цех хүрэх зам нь байнга ашиглагдах тул сайжруулсан, байнгын 2 зурвастай 12 м өргөн зам тавина.

***Засвар механикийн цех*****:** Ухайн техникийн үйлчилгээний дэд бүтэц нь ухаж ачих, зөөж тээвэрлэх, бутлах, шигших тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалт бүхий засварын жижиг газар байна.

***Хөрсний овоолго*****:** Тус дайрганы орд нь хөрс хуулалт харьцангуй багатай тул хөрсний овоолго бага байна.ил уурхайн баруун талд дунджаар 150-300 м зайд гадаад одоолго үүсгэнэ. Шимт хөрсний овоолгын эзлэхүүн 31.9мян.м3 байна.

***Ил уурхай*****:** ил уурхайн нь 88479.56 $м^2$ талбайн хөрс хуулна.

## 2.11.Усан хангамж

Уурхайн нь технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй. Уурхайд 35-44 хүн ажиллах ба хоногт 1.75-2.2 $м^2$, жилд 180 хоногт 315-396 $м^3$ усыг унд ахуйн хэрэглээнд ашиглана. Унд ахуйн усыг зөөврөөр хангана.

## 2.12.Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, 1 ба 2-р шатны бутлуур, шигшигч, конвейр, засварын цех, гэрэлтүүлэг болон болон бусад жижиг хэрэглэгчид байна. Эдгээр цахилгаан хэрэглэгчдийг уурхайгаас 1 км зайд өнгөрөх 35кВ-ын өндөр хүчдэлээс салгасан агаарын шугам татан эрчим хүчээр хангахаар тооцсон байна.

## 2.13.Хөдөлмөр аюулгүй ажиллагаа

Тус уурхай нь Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль, "Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мордох аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм" болон "Ашигт малтмал газрын хэвлийн тухай хууль”, "Хөдөлмөрийн тухай хууль” тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, зааврын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

# БҮЛЭГ 3. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Амьдралын илч” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

**Тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга**

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Баян ам” нэртэй дайрганы ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

“Амьдралын илч” ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөлиийг бууруулах ажлууд болох тоосжилт үүсэх үед усалгаа, өнгөн хөрсний овоолго, замыг тогтмол нэг маршрутаар явуулах, замын тэмдэг тэмдэглэгээ, ШТМ-ын зориулалтын сав байршуулах, дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагаас авсан саналын дагуу хийх, хог тээвэрлэлтийн гэрээ байгуулах, хог хаягдлын цэгийг хашаажуулах, хөрс, усны шинжилгээ хийх, галаас хамгаалах багаж хэрэгсэл, галаас сэргийлэх самбар тэмдгийг шаардлагатай газруудад байршуулах, хөдөлмөр хамгааллын сургалт зохион байгуулах, жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

# БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны нөлөөллийг магадлан жагсаах аргаар (checklist) тодорхойлъё. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм эдийн засаг, бусад гэсэн 6 үндсэн бүлэгт хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж эрчимжилтийг “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

*Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл*

| № | Байгаль орчны үзүүлэлт | Хэлбэр | | | Хугацаа | | | Нөлөө | | Эрчим | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино | Дунд | Урт | Буцах | Буцалтгүй | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
| **Байгалийн экосистемийн өөрчлөлт** | | | | | | | | | | | | |
| 1 | Газрын доорхи усны урсац, горим, чанар өөрчлөгдөх | | 0 | | | 0 | | | 0 | 0 | | |
| 2 | Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах | - | | | | - | | | - | | | - |
| 3 | Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах | - | | | | - | | | - | | | - |
| 4 | Хөрс хуулалт, дайрга олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх | - | | | | - | | | - | | - | |
| 5 | Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай | - | | | | - | | | - | | - | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх | | | | | | | | | | | |
| 6 | Бичил уур амьсгалын өөрчлөлт | | - | | - | | | - | | | - | |
| **Байгалийн нөөциййн- ашиглалт** | | | | | | | | | | | | |
| 7 | Газрын гадаргын нөөц баялаг | - | | | | - | | | - | | - | |
| 8 | Газрын доорхи усны нөөц | | 0 | | | 0 | | | 0 | 0 | | |
| 9 | Бэлчээрийн нөөц | - | | | | - | | - | | | - | |
| 10 | Эрчим хүчний нөөц | | | - | | - | | | - | - | | |
| **Байгаль орчны өөрчлөлт** | | | | | | | | | | | | |
| 11 | Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор газрын доорхи ус бохирдох | | - | | - | | | - | | | - | |
| 12 | Гадаргын усны бохирдолт | - | | | | - | | - | | - | | |
| 13 | Ил уурхай, хөрсний овоолго, зам зараг гадаргуугаас тоос босох, тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтаас үүсэх хорт хий зэргээс агаар бохирдох | - | | | | - | | - | | | | - |
| 14 | Шатах, тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотой хөрс бохирдох | - | | | | - | | - | | | | - |
| 15 | Дуу чимээ шуугианы нөлөөлөл | - | | | - | | | - | | | - | |
| **Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл** | | | | | | | | | | | | |
| 16 | Байгалийн төрх өөрчлөгдөх | - | | | | - | | | | - | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | - | | | | - | | | | - | | |
| 18 | Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | - | | | | - | | | | - | | |
| 19 | Түүх, соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | - | | | | - | | | - | - | | |
| **Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл** | | | | | | | | | | | | |
| 20 | Улсад татвар төлөх, орлого нэмэгдэх | + | | | | + | | | + | | + | |
| 21 | Орон нутгийн орлого нэмэгдэх | + | | | | + | | | + | | + | |
| 22 | Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | + | | | | + | | + | | | + | |
| 23 | Ажлын байр нэмэгдэх | + | | | | + | | + | | | + | |
| 24 | Уурхайн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх | + | | | | + | | | + | | + | |
| 25 | Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | - | - | | | - | | | | | - | |
| **Бусад** | | | | | | | | | | | | |
| 26 | Ахуйн бохир усны цооног, бие засах газар, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа батгана, шавж үржих | - | | | - | | | - | | | - | |
| 27 | Байгалийн гамшиг, аюул осол | - | | | - | | | | - | | - | |
| | **Нийт** | **22** | **5** | **1** | **5** | **22** | **0** | **10** | **13** | **8** | **15** | **4** |

**Тайлбар:** Сөрөг нөлөөлөл байгааг: хүчтэй /-/, дунд /-/, бага /-/

Нөлөөлөл байхгүй /0/

Эерэг нөлөөлөл байгааг /+/ гэсэн тэмдэглэлээр үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн 22 нь шууд, 5 нь шууд бус, 1 нь өөрөө зохицуулагдах байна. Нийт нөлөөллийн 8 нь бага эрчимтэй, 15-дунд эрчимтэй, 4-хүчтэй байна. Нийт нөлөөллийн 74.1% нь сөрөг, 18.5% нь эерэг, 7.4% нь нөлөөлөлгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх нөлөөллийг тус бүрээр авч үзвэл уурхайн хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас хөрс болон ургамалд шууд, хүчтэй, дунд хугацааны турш буцалтгүй нөлөөлөх бол геологийн тогтоц өөрчлөгдөх, ойр орчимд нутагладаг ан амьтадын амьдрах орон зай өөрчлөгдөх нь дунд эрчимтэй сөрөг нөлөө үзүүлнэ.

Байгалийн нөөц ашиглалтын хувьд газрын нөөц болон бэлчээрийн нөөцөд дунд хугацаанд, дунд зэргийн эрчимтэй, шууд сөрөг нөлөөтэй. Харин уг төсөл нь ус ашиглахгүй тул газрын доорхи усны нөөцөд нөлөөгүй байна.

Төсөл хэрэгжих орчмын агаар, хөрсний чанарт шууд байдлаар, дунд хугацаанд, хамгийн их эрчимтэй буцах нөлөөлөл, газрын доорхи усны чанарт болон дуу шуугианы нөлөөлөл бага хугацаанд, буцах байдлаар дунд зэрэг нөлөөлнө.

Төслийн үйл ажиллагаанаас байгалийн төрх, түүх соёлын дурсгалт зүйлст дунд хугацаанд, шууд, сул эрчимтэй сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Төсөл хэрэгжих орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудалд шууд байдлаар, дунд хугацаанд, буцалтгүйгээр дунд зэргийн эрчимтэй эерэг нөлөө үзүүлнэ.

***Болзошгүй сөрөг нөлөөлөл:***

***Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:***

- Тээвэрлэлтийн хөдөлгөөний улмаас агаарын тоосжилт үүснэ, дизель түлшээр ажилладаг машин механизмаас утаа тортог, хий гарах,
- Тэсэлгээнээс үүссэн тоосжилт, дуу чимээ,
- Хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

***Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:***

- Уурхайн олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэлд орох,
- Шимт хөрсний овоолго үүсгэхэд түүнд хөрс, ургамал дарагдах,
- ШТС, тэсрэх материалын агуулах зэрэг байгууламж барихад хөрс, ургамал эвдрэлд орох,
- Уурхайн хөрс дайрга тээвэрлэлтийн улмаас хөрс эвдрэх талхлагдах,
- Ахуйн хог хаягдал хөрсөнд биологийн бохирдол үүсгэх,
- Аюултай хог хаягдал нь хөрсөнд удаан хугацаанд хадгалагдах бөгөөд хоруу чанар нь хөрсөн орчинд сөрөг нөлөөлөл үүсгэх эх үүсвэр болно.

***Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:***

- Газрын доорх усны нөөц хомсдох,

- Шатах, тослох материал асгарч тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах.

***Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:***

- Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болно.
- Тээврийн хэрэгсэл, тэсэлгээний үеийн дуу чимээнээс хүн амьтан үргэж, дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх.

***Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:***

- Төслийн хугацаанд уурхайн нарийн мэргэжил шаардагдахгүй ажилд орон нутгийн иргэдээс ажиллуулах ба цөөн хэдэн хүнийг ажлын байраар хангах бөгөөд олборлолтын хугацаанд нутгийн иргэдээс өргөн хэрэглээний бараа, хүнсний тодорхой бүтээгдэхүүн (мах, цагаан идээ, гурил, будаа мөн ариун цэврийн бүтээгдэхүүнүүд г.м) худалдан авах зэргээр бага хэмжээний орлогыг нутгийн иргэдэд оруулах юм.
- Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.
- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

# БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

***Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт***

| № | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2025 он /төгрөг/ |
|---|---|---|---|
| **Агаарын орчин** | | | |
| 1 | Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх | Дотоод тээврийн замаас тоосжилт бууруулахын тулд усалгаа хийсэн. Уурхайн дотоод тээврийн зам дагуу тоосжилтоос хамгаалах усалгааг хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд 1тн-ын багтаамжтай саваар зөөвөрлөн, 7 хоногт 2 удаа усалгаа хисэн. | Дотоод төлөвлөлтөөр |
| 2 | Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах, хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх | Туслан гүйцэтгэгч компани оруулдаг тул тэр компани өөрсдөө тхникийн үзлэгт хамруулдаг. | - |
| 3 | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийн төлбөрийг төлнө. | - | - |
| 4 | Тэсэлгээг тодорхой хуваарийн дагуу хийх, тэсэлгээ хийх үеийн салхины хурд, чиглэлийг харгалзан үзэх, хүчтэй салхитай өдөр тэсэлгээний ажил хийхгүй байх | 2025 онд тэсэлгээ хийгээгүй. | - |
| 5 | Уурхай нь суурин газартай ойрхон байрладаг тул олборлолтын үед дуу чимээний нөлөөллийг аль болох бага хэмжээнд байлгах, шөнийн цагаар уурхайн үйл ажиллагааг явуулахгүй байх | Уурхай нь суурин газартай ойрхон байрладаг тул олборлолтын үед дуу чимээний нөлөөллийг аль болох бага хэмжээнд байлгаж шөнийн цагаар уурхайн үйл ажиллагааг явуулаагүй. | - |

| | | | |
|---|---|---|---|
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг** | | | |
| 1 | Газрын төлбөрийг жил бүр төлөх. | Газрын төлбөрийг төлсөн. | 8,335,540.0 |
| 2 | Уурхайн талбайн эргэн тойронд уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх, сайжруулах. | Зөвхөн тогтсон замаар тээврийн хэрэгслийг явуулсан, замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. | 500,000 |
| 3 | Өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах, нөхөн сэргээлтэнд ашиглах. | - | - |
| 4 | Шимт хөрсний овоолгыг салхинд тархахаас сэргийлж хамгаалах, ургамалжуулах | - | - |
| 5 | Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах | Шатах тослох материал гардаггүй. | - |
| 6 | Шатах тослох материалыг хадгалах зориулалтын сав байрлуулах, аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх | - | - |
| **Усан орчин** | | | |
| 1 | Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх | Ахуйн бохир усыг ил задгай асгаагүй. | - |
| 2 | Уурхайн талбайд гаргасан гүний худгийг бохирдохоос сэргийлж, хашаалж хамгаалах | 2026 оны БОМТ-нд тусгана. | - |
| 3 | Гүний худгийг тоолууржуулах | Гүний худгийг тоолууржуулсан. | 300,000 |
| 4 | Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүр гаргуулж, усны төлбөрийг цаг тухай бүрт төлөх | Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, усны төлбөрийг цаг тухай бүрт төлсөн. | Үйл ажиллагааны зардалд орсон. |
| **Нийт дүн** | | | **9,135,540.0** |



Нэгж талбарын дугаар 1260111541

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025 оны 07 сарын 08 өдөр № 01113-2022/01678 Улаанбаатар хот

Монгол Улсын Газрын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 07 сарын 16-ны өдрийн 01113-А/655/2018 тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтэн Галтүү овогтой Шүүэрт, газар ашиглагчийг төлөөлж

( Амьдралын илч ХХК )

(иргэн, аж ахуйн нэгжийн нэр)

Амьдралын илч-ны Захирал Ж.Амьдралтүү

нар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын / Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2018 оны 07 сарын 16-ны өдрийн 01113-А/655/2018 тоот шийдвэр энэхүү газар ашиглуулах гэрээ байгуулах үндэслэл болно.

1.2. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгана.

1.2.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг харуулсан зураг схем.

1.2.2. Газар ашиглуулагчаас газар ашиглагчид уг газрыг хүлээлгэн өгсөн акт.

1.2.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулна.

1.3. Энэхүү гэрээний 1.2.-т заасан бүрдүүлбэр нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнийг бүрдүүлж хийгдээгүй тохиолдолд уг гэрээ хүчингүйд тооцох үндэслэл болно.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Ашиглалтад олгосон газрын нийт хэмжээ 278622

Үүнээс:

| Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт | Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ |
|---|---|
| Уурхайн газар | 278622 |
| Уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй талбай | 28960.23 м2 |
| Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн талбай | 0 м2 |
| Газар ашиглах хугацаа | 1 |

2.2. [illegible]

2.3. [illegible]



Гурав. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг, хариуцлага

Дөрөв. Газар ашиглагчийн эрх, үүрэг, хариуцлага

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

Зургаа. Гэрээний нөхцөл



Долоо. Бусад

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч:

Нийслэлийн газар зохион байгуулалтын алба

Гэрээ байгуулсан

Газар ашиглагч: Амьдралын илч ХХК

Зураг 3. 2025 оныгГазар ашиглах гэрээ




***Зураг 4. Уурхайн дотоод тээврийн зам***



***Зураг 5. Уурхайн дотоод тээврийн зам***



***Зураг 6. Уурхайд таних тэмдэг байршуулсан байдал***




***Зураг 7. Уурхайд таних тэмдэг байршуулсан байдал***

### 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2025 онд нөхөн сэргээлт хийгдэхгүй болно.

### 5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

***Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт***

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2025 он /төгрөг / |
|---|---|---|---|---|
| 1 | Дүйцүүлэх хамгаалах ажил хийх | "Тэгш газар" ХХК-ийн хэрэгжүүлж буй Дүйцүүлэн хамгааллын хөрөнгөөр Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Улсын нэгдсэн 2 дугаар эмнэлгийн хажуу талын нийтийн эзэмшлийн талбайд Нарс, Гүйлс, Монос мод суулгаж, зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн. | Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн дүйцүүлэн хамгааллын хөрөнгөөр "Тэгш газар" ХХК нь Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн 866 $м^2$ талбайг зүлэгжүүлэн, нийтдээ 270 мод тарих ажлыг хийсэн. Тайланг хавсралтаар оруулаа. | 2,000,000 |
| 2 | Тэбрум мод | Уурхайн орчинд ногоон байгууламж бий болгох. | Уурхайн талбайд нийт 300 ш улиас, бургас, хайлаас модыг тарьж, арчилгаа хийн тордож, усалж байна. | 1,800,000 |
| **Нийт** | | | | **3,800,000** |



*Зураг 9. Уурхайн талбайд мод бут тарьсан байдал*



*Зураг 10. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил*



*Зураг 11. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил*




*Зураг 12. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил*




*Зураг 13. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил*




*Зураг 14. Дүйцүүлэн хамгааллын ажлаар хийсэн ажил*

## 5.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ тэдэнд өгөх нөхөн олговрыг хэдийд өгөх, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тэдний саналыг харгалзан хэдийд зохион байгуулахыг тодруулан тусгана. Энэхүү төслийн хувьд иргэд оршин суугчдад үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байна.

## 5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

### 5.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал, 2025 он /төгрөг/ |
|---|---|---|---|
| 1 | Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх | Ажил эхлэхийн өмнө ажилтан бүрт хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгч ажилладаг. | - |
| 2 | Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан. | 500,000 |
| 3 | Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, ажилласан. | 7,820,000 |
| 4 | Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг байршуулах | Галын дүгнэлт 2025 онд гаргуулсан. Гал унтраах галын хор, хүрз зэрэг хэрэгслийг зохих газруудад байршуулсан. | 500,000 |
| 5 | Галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, нөхөж тавих | Галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж тэмдгийг байршуулсан. | 300,000 |
| 6 | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, хянаж ажилласан. | - |
| 7 | Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх | - | - |
| 8 | Тэсэлгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх | 2025 онд тэсэлгээ хийгдээгүй. | - |
| 9 | Уурхайн тэсэлгээний үед аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах, мэргэжлийн тэсэлгээчнээр гүйцэтгүүлэх | - | - |
| **Нийт** | | | **9,120,000** |



*Зураг 15. Галаас сэргийлэх багаж хэрэгсэл байршуулсан байдал*




*Зураг 16. Галын аюулаас сэргийлэх анхааруулах самбар*




*Зураг 17. Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан байдал*



*Зураг 18.Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авах эмийн сан*



*Зураг 19.Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар*

## 5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

***Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт***

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2025 он /төгрөг / |
|---|---|---|---|
| 1 | Хог тээвэрлэлтийн гэрээ байгуулж, хог хаягдлыг тухай бүрт тээвэрлүүлэх | Хог тээвэрлэлтийн гэрээ байгуулж, хог хаягдлыг тухай бүрт тээвэрлүүлсэн. | 990,000 |
| 2 | Хог хаягдлын ангиллын зориулалтын хогийн сав байршуулах | Хог хаягдлын ангиллын зориулалтын хогийн сав байршуулсан. | 300,000 |
| 3 | Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх | Ашигласан шатах тослох материал гардаггүй. | - |
| 4 | ШТМ болон аюултай хог хаягдлыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох | - | - |
| 5 | Тэсэлгээний үед хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдлыг тэсэлгээний мэргэжлийн байгууллага хариуцаж, буцаан авч явж устгуулах. | 2025 онд тэсэлгээ хийгдээгүй. | 100,000 |
| **Нийт дүн** | | | **1,390,000** |



*Зураг 21. Хог хаягдлын цэгийг хашаажуулсан байдал*

## 5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2025 он /төгрөг / |
|---|---|---|---|
| 1 | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн. “Эко ногоон баялаг” ХХК | Мэргэжлийн байгууллагатай тохиролцсоноор |
| 2 | Байгаль орчны аудит хийлгэх | Мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна. “Эко Вишн” ХХК | Мэргэжлийн байгууллагатай тохиролцсоноор |
| 3 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын тогтоож мөрдөх арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож ажилласан. | Дотоод төлөвлөлтөөр |
| 4 | Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах | 2025 онд түрээсийн компани оруулсан учраас эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй. | - |
| 5 | Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх | Орон нутагтай нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>1. Үерийн усанд автсан гудамжны замыг шороогоор булж тэгшилсэн<br>2. 1-р хороонд үерийн даланг 20 машин дайргаар янзалж өгсөн. | 5,000,000 |
| 6 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэсэн. | - |
| **Нийт дүн** | | | **5,000,000** |



*Зураг 22. Нийгмийн хариуцлагын хүрээнд үерийн усанд автсан гудамжны замыг шороогоор булж тэгшилсэн байдал*

## 5.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 11. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөөний биелэлт*

| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацааны тов | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| “Амьдралын илч” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн иргэд, байгаль хамгаалагч | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулга хийх | 2025 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажилласан тухай | 11-р сарын 01-ны өдрийн дотор | БОМТ болон, БОМТ-ний биелэлтийн тайланг хянуулахаар ажиллаж байна. |

## 5.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

*Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Зардал, 2025 он /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| **Агаарын орчин** | | | | |
| 1 | Агаарын бохирдуулагч бодис (SOx, NOx, TSP гэх мэт) | -Ил уурхай орчмоос, -Бутлуурын хэсгээс | - | - |
| **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| 1 | Ерөнхий химийн шинжилгээ болон хүнд элемент (Cu, Cr, Pb, Cd, As, Zn) | -Ил уурхай орчмоос, -Кемп орчмоос. | Хөрсний агрохимийн шинжилгээг “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хөрсниий лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнг хавсаргалаа | 84,000 |
| 2 | Хөрсний эрүүл ахуй | -Тээвэрлэлтийн замаас. | | |
| **Усан орчин** | | | | |
| 1 | Химийн ерөнхий шинжилгээ | Ундны усны худаг-1 | Усны шинжилгээг “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн лабораторид шинжлүүлсэн. Шинжилгээний дүнг хавсаргалаа | 33,000 |
| **Нийт дүн** | | | | **117,000** |






“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-14/1

Захиалагч: **“Эко ногоон баялаг” ХХК**
Дээж авсан цэг: **“Амьдралын элч” ХХК, Налайх дүүрэг, Баян ам дайрганы орд**
Сорьц авсан огноо: **2025 оны 10 сар 06 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **10 сарын 14**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох суурьнууд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| Дээж 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-20 | 8.00 | 0.019 | 0.046 | 1.97 | 0.00 | 0.12 | 14 | 9 | 1.5 | 2 |
| 2 | 20-40 | 8.03 | 0.011 | 0.025 | 1.73 | 0.00 | 0.04 | 13 | 11 | 1.4 | 6 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Дээж 1 | | | | | | | | |
| 1 | 0-20 | 1.6 | 67.0 | 13.5 | 7.5 | 3.6 | 6.8 | 17.9 |
| 2 | 20-40 | 2.1 | 64.8 | 14.6 | 8.3 | 2.9 | 7.3 | 18.5 |

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Дээж 1 | 0-20 | 13.4 | 22.5 | 0.0 | 25.6 | 10.9 | 8.2 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Хордуулах түвшин * *Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд* MNS3310:1991, MNS ISO10390, *хөрсний механик бүрэлдэхүүн* MNS6824:2020, *Хүнд металлуудыг - хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ : Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2025 ОНЫ 10 САРЫН 14 1

*Зураг 23. Хөрсний зүсэлт, Хөрсний агрохимийн, хөрсний хүнд металлын шинжилгээний дүн*





*Зураг 24. Гүний худаг, усны шинжилгээний дээж авч буй байдал*

“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
**ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

**№ 25/10-13/-1**

Захиалагч: **“Эко ногоон баялаг” ХХК**
Дээж авсан цэг: **“Амьдралын элч” ХХК, Налайх дүүрэг Баян ам дайрганы орд**
Сорьц авсан огноо: **2025 оны 10 сар 06 өдөр**
Уст цэгийн төрөл: **Гүний худаг**
Харилцах утас:
Аргын стандарт: **MNS1097:2023, MNS ISO 7888:1999, MNS ISO 9297:2005**

1. УСНЫ ХИМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Катион | 1 $дм^3$ | | | Анион | 1 $дм^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |
| $Ca^{++}$ | 56.00 | 2.79 | 68.91 | $CO_3^{--}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 11.00 | 0.90 | 22.32 | $HCO_3^-$ | 186.00 | 3.05 | 75.02 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | $Cl^-$ | 20.00 | 0.56 | 13.88 |
| $K^+$ | 2.00 | 0.05 | 1.26 | $SO_4^{--}$ | 17.00 | 0.35 | 8.72 |
| $Na^+$ | 7.00 | 0.30 | 7.51 | $NO_3^-$ | 6.00 | 0.10 | 2.38 |
| **Дүн** | **76.00** | **4.06** | **100.00** | **Дүн** | **229.00** | **4.06** | **100.00** |

Анион катионуудын нийлбэр:
($\sum_{A+K}$ **305 мг/л**
$HCO_3$-ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: **212 мг/л**
***Физик үзүүлэлтүүд***
Өнгө: 0-**өнгөгүй**
Үнэр: 0-**үнэргүй**
Булингар: **булингаргүй**

Тунгалаг: **Тунгалаг**
Хуурай үлдэгдэл, мг/л: **192 ppm**
Ерөнхий **хатуулаг: 3.69 мг-экв/л**
*/ бага хатуулагтай ус /*
Урвалын орчин: pH- **7.81**
Цахилгаан дамжуулах чадвар:
EC **-0.482 ds/m**
TDS: **244 ppm**

$$M(0.31) = \frac{HCO3\ 75\ [Cl\ 14\ SO4\ 9]}{Ca\ 69\ [Mg\ 22\ Na\ 8]}$$

***Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.***

*Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ MSc
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

*Зураг 25. Усны шинжилгээний дүн*

## 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ

“Амьдралын илч” ХХК-ийн 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОНХЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулллаа.

